*Журмын зургаадугаар хавсралт*

*ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ*

<table>
<tr><th>№</th><th colspan="5">Хөтөлбөр/төслийн агуулга</th><th colspan="6">Гүйцэтгэл</th></tr>
<tr><td>1</td><td colspan="5">Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (уялдаа, холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)<br><br>ТА 9037 МОН Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх төсөл<br>2016 оны 04 сарын 01-нд байгуулагдсан.</td><td colspan="6">Төсөл, хөтөлбөрийн зорилго<br><br>Эмнэлгийн бие даасан байдлыг дэмжих, Туршилтын эмнэлгүүд дээр ажиллаж шаардлагатай хууль эрх зүйн орчныг бий болгох,</td></tr>
<tr><td>2</td><td colspan="5">Санхүүжилтийн эх үүсвэр<br><br>Азийн хөгжлийн банк</td><td colspan="6">Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж<br><br>Буцалтгүй тусламж</td></tr>
<tr><td>3</td><td colspan="5">Хэрэгжүүлэх байгууллага /хэрэгжих нийт хугацаа/<br><br>Нийслэлийн болон Сэлэнгэ, Төв аймгийн нэгдсэн эмнэлэг</td><td colspan="6">Үндсэн хэрэгжүүлэх байгууллага<br><br>ЭМЯ</td></tr>
<tr><td>4</td><td colspan="5">Төсөл хөтөлбөрийн зорилтууд</td><td colspan="6">Зорилт 1. Эмнэлгийн засаглал Төлөөлөн удирдах зөвлөл, эмнэлгийн захиралтай холбогдох журам зааврыг эцэслэн боловсруулж баталгаажуулан оношийн хамааралтай бүлгийг шинэчлэн боловсруулахад чиглэнэ.<br>Зорилт 2. Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх техник туслалцааны төслийн хүрээнд хэрэгжүүлэх чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа<br>Бүх сургалт, зөвлөлдөх уулзалтуудыг сурган заах арга зүйн сүүлийн үеийн арга техникийг ашиглан оролцооны аргаар явуулах ба оролцогчид сурсан зүйлээ ажлын байран дээрээ ашиглан, эмнэлгийн гүйцэтгэл, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэнэ.<br>Зорилт 3. Эмнэлгийн бие даасан багдлыг бэхжүүлэх<br>Сонгогдсон эмнэлгийн удирдлагын багаас эмнэлэг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, эмнэлгийн бие даасан төсөв боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.</td></tr>
<tr><td rowspan="4">5</td><td rowspan="4">Зардал</td><td>Төсөв ( нийт шаардагдах зардал )</td><td colspan="3">Төсөв<br>1,100,000,000 ам доллар</td><td colspan="3">Гүйцэтгэл</td><td colspan="3">Хувь<br>59.44%</td></tr>
<tr><td>Үүнд:</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Багц 1</td><td>Сургалт</td><td>136000</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Багц 2 гэх мэт</td><td>Захиргааны зардал</td><td>20000</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td colspan="5">Төсөл хөтөлбөрийн зорилт:</td><td colspan="6">Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| 6 | *1-р зорилтын хүрээнд:*<br>*Эмнэлгийн тусламж, үйлчилгээний* тухай Монгол улсын хуулийн 18.1-д заасны дагуу төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг улсын төсвөөс болон даатгалын сангаас тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэхээр заасны дагуу DRG (онош ойролцоо бүлэг) боловсруулах үйл ажиллагааны төслийн хүрээнд эхлүүлэн хэрэгжүүлж байна. DRG боловсруулах үйл ажиллагааг төслийн эмнэлгүүд болон бусад эмнэлгүүдийг оролцуулан нийт 10 эмнэлэг (төрөлжсөн мэргэжлийн болон нэгдсэн эмнэлгүүд) судлан тусламж, үйлчилгээний ангилал, өртгийн жин, өртгийг тооцон ажиллаж байна. Энэ үйл ажиллагаа төсөл хэрэгжүүлэх хугацаанд хэрэгжиж цаашид улсын төсвийн санхүүжилт болон Даатгалын сангаас санхүүжилт авах (төлөвлөх, зарцуулах, тайлагнах) бүх эмнэлгүүдэд хэрэгжих юм | *1- р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл*<br><br>*Гүйцэтгэл 16.16%* |
| | *2-р зорилтын хүрээнд:*<br>Төсөл ЭМЯ-наас сонгосон 6 эмнэлэгт хэрэгжиж байна. Эдгээр эмнэлгүүдийн удирдлагын баг болон хүний нөөц, чанар, санхүү хариуцсан мэргэжилтнүүдэд болон аймаг, орон нутгийн эмнэлгүүдийн мэргэжилтнүүдэд сургалт явуулж байна | *Гүйцэтгэл 27.15%* |
| | *3-р зорилтын хүрээнд:*<br>Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүй байна. Бэлтгэл ажил хийгдэж байна. Сонгогдсон 3 эмнэлэгт бие даасан үйл ажиллагаа эхлээд явж байгаа бөгөөд энэ хүрээнд тухайн эмнэлэг бие даасан өөрсдийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа (Улсын Гуравдугаар төв эмнэлэг, арьсны өвчин судлалын үндэсний төв, Төв аймгийн нэгдсэн эмнэлэг) эхлэн явагдаж байна. Эдгээр эмнэлгүүдэд ментор хийх аргааг бие даасан үйл ажиллагааг нь төслөөс дэмжин ажиллаж байна | *Гүйцэтгэл 10.12%* |
| 7 | *4-р зорилтын хүрээнд:* | - |
| 8 | *Дүгнэлт (ророт, дутагдал, анхаарах асуудлууд* | |
| 9 | *Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх* | |